НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны гэрээний дагуу болон хувийн шугамаар суралцах гадаадын иргэнийг Отгонтэнгэр Их Сургууль (цаашид ОТИС гэх)-д суралцуулах үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2 Монгол улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон ОТИС-ийн холбогдох журмыг үндэслэн ОТИС-ийн боловсролын зэрэг олгох болон зэргийн бус сургалтад гадаадын иргэнийг суралцуулахад энэхүү журмыг баримтална.

1.3 Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал ОТИС-ийн захиргааны зөвлөл хэлэлцэж, захирал шийдвэр гаргана.

ХОЁР. ЭЛСЭЛТ, БҮРТГЭЛ

2.1 Гадаадын иргэнийг оюутнаар элсүүлэн суралцуулах асуудлыг Сургалтын нэгдсэн алба, Гадаад харилцааны алба хамтран хариуцан ажиллана. Сургалтын нэгдсэн алба нь ОТИС-ийн дүрмийн дагуу томилогдсон Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлын удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг сургуулийн үндсэн нэгж болно. Гадаад харилцааны алба нь захирлын удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг сургуулийн үндсэн нэгж болно.

2.2 ОТИС-ийн боловсролын зэрэг олгох сургалтад суралцах гадаадын иргэн нь Монгол Улсад мөрдөгдөж буй боловсролын агуулга түвшин, стандарттай дүйцэхүйц өмнөх шатны боловсрол эзэмшсэн байна.

2.3 Элсэлтийн үйл ажиллагааг хичээлийн жилд хоёр удаа зохион байгуулна. Зэрэг олгох хөтөлбөрт элсэх тухай хүсэлтийг намрын улиралд суралцах бол 5 дугаар сарын 01-нээс 8 сарын 20-ны хооронд, хаврын улиралд суралцах бол 10 дугаар сарын 01-ээс 12 дугаар сарын 10-ны хооронд тус тус гаргаж бүртгүүлнэ.

2.4 Хичээл дараах байдлаар зохион байгуулагдана.Үүнд;

- Танхим
- Цахим
- Танхим, цахим хосолсон.

2.5 Суралцахыг хүсэгч нь элсэн суралцах анкетыг тус сургуулиас бэлтгэн гаргасан маягтын дагуу бэлтгэж Сургалтын нэгдсэн албанд ирүүлнэ. Өргөдөлд дор дурдсан материалыг хавсаргасан байна.

- Хувийн өргөдөл;
- Гадаад паспортын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /5 жил хүртэл хүчинтэй хугацаатай байх/;
- Бүх шатны боловсролын үнэмлэх, диплом, хавсралтын /эх хувь, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, монгол хэлнээ хөрвүүлж нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны баталгаа/;
- Хэрэв байгууллагын нэр дээр суралцах гэж буй бол тухайн иргэнийг Монгол Улсад суралцахаар илгээж буй байгууллагын тодорхойлолт /албан ёсоор баталгаажиж

Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулж авсан байх/;
- Эрүүл мэндийн бичиг /ХДХВ/ДОХ-ын шинжилгээний бичгийн хамт/;
- 3х4 хэмжээний цээж зураг /Сүүлийн 6 сарын хугацаанд авхуулсан байх/;
- Элсэлтийн хураамж;

2.6 Англи хэлээр сургалт нь явагддаг, боловсролын зэрэг олгох сургалтын хувьд гадаадын иргэнээс монгол хэлний мэдлэг, чадвартай байхыг шаардахгүй боловч, тухайн хөтөлбөрийн шаардлагад нийцсэн Англи хэлний түвшинтэй байхыг шаардана. Энэ тохиолдолд англи хэлний мэдлэг, чадварын түвшинг илтгэх бичиг баримтыг (IELTS, TOEFL гэх мэт шалгалтын оноо нь хүчинтэй гэрчилгээ) элсэх хүсэлт гаргах үед хавсаргаж ирүүлнэ.

2.7 Хөтөлбөрийн онцлогоос хамаарч бүтцийн сургууль, мэргэжлийн тэнхимээс бусад тусгай шаардлагыг элсэгчдэд тавьж болно.

2.8 Сургалтын нэгдсэн алба дээрх материалыг хүлээн авч хянаад шаардлага хангасан нөхцөлд элсэлтийн шалгалтыг зохион байгуулж, элсэлтийн шалгалт өгөх зөвшөөрлийн хуудас олгож шалгалт авна. Шалгалтад тэнцсэн тохиолдолд тус сургуульд суралцах эрхийн бичиг олгоно. Эрхийн бичиг нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

2.9 Тус сургуульд суралцах эрхийн бичиг олгогдсон суралцахыг хүсэгчийг ОТИС-ийн захиралд танилцуулж суралцагчтай Сургалтын нэгдсэн албаны дарга гэрээ байгуулна. Гэрээ нь тус сургуулиас батлан гаргасан загварт үндэслэгдсэн байна.

2.10 Гэрээ байгуулсан гадаадын иргэнийг ОТИС-ийн захирлын тушаалаар элсүүлэн Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгэнэ.

2.11 Суралцагч Гадаад оюутантай байгуулсан гэрээнд заасан сургалтын төлбөр, үйлчилгээний хураамжийг ОТИС-ийн Удирдах зөвлөлийн хурал, захиргааны зөвлөлийн хурлаар батлагдсан Гадаад оюутны сургалтын төлбөр, үйлчилгээний хураамжийг бүрэн төлж баримтыг хуулбарын хамт санхүүд тушаана.

2.12 Танхимаар суралцах суралцагчийг Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн тухай хууль, дүрэм, журамд заасны дагуу эрүүл мэндийн даатгалд хамруулна. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суралцагч өөрөө хариуцна. Суралцагчийн эрүүл мэндийн даатгалд даатгуулах үүргийг гадаад харилцааны алба хүлээнэ.

2.13 Танхимаар суралцах суралцагчийн хүсэлтээр ОТИС өөрийн оюутны дотуур байранд орох тохиолдолд гэрээ хийж, төлбөртэйгөөр суулгана. Оюутны дотуур байрны ачаалал болон бусад шалтгаанаар ОТИС-ийн оюутны дотуур байранд суугаагүй суралцагчид амьдрах байр, орон сууцаа олоход нь туслалцаа үзүүлж болно. Байр орон сууц худалдан авах, хөлслөх, зардлыг суралцагч өөрөө хариуцна.

ГУРАВ. ВИЗ, ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ

3.1 Сургалт нэгдсэн алба нь бүрдүүлсэн материал, суралцах эрхийн бичиг, суралцагчтай байгуулсан гэрээ, сургалтын төлбөрийн баримтыг үндэслэн тухайн суралцагчийн тус сургуульд суралцах эрхийн ангиллаар орж ирэх зөвшөөрөл олгох хүсэлтийг Боловсрол, гадаадын иргэн харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан элсэгчийн харьяаллын дипломат төлөөлөгчийн газарт явуулна.

3.2 Суралцагч харьяа дипломат төлөөлөгчийн газраас виз авч Монгол Улсад ирэх бөгөөд ирнээс хойш ажлын 2 өдрийн дотор тус сургуулийн гадаад харилцааны албанд бүртгүүлж, ажлын 7 өдрийн дотор гадаадын иргэн харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

3.3 Монгол Улсад орж ирснээс хойш 21 хоногийн дотор сургуулийн захирлын зөвшөөрлийн дагуу Боловсрол, гадаадын иргэн харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудаас Монгол Улсад жилээр оршин суух зөвшөөрөл авна.

3.4 Монгол Улсад оршин суух зөвшөөрөл авахад суралцагчийн бүртгүүлэх материалын жагсаалтыг дурдав. Үүнд:

- Боловсрол, гадаадын иргэн харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандсан албан бичиг /Сургуулийн суралцагчид оршин суух зөвшөөрөл хүссэн/
- Сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн /гэрчилгээ/ хуулбар
- Суралцагчийн эрүүл мэндийн бичиг /ХДХВ/ДОХ-ын шинжилгээний бичиг/
- Суралцагчийн паспортын хуулбар /визтэй хуудасны хамт/
- Зөвшөөрлийн хураамж
- Суралцагчтай сургалтын нэгдсэн алба байгуулсан гэрээний хуулбар
- Оршин суугаа хорооны тодорхойлолт
- Бүртгэлийн анкет
- 3х4 хэмжээний 1 хувь цээж зураг /сүүлийн 6 сарын хугацаанд авхуулсан байх/

3.5 Магистр, докторын хөтөлбөрт элсэн суралцаж байгаа гадаад суралцагчид нь суралцах хугацаандаа гэр бүлийн гишүүдээ урилгаар ирүүлж Монгол Улсад хамт оршин суух хүсэлтээ суралцаж эхэлснээс хойш 6 сарын дараа Гадаад харилцааны албанд өргөдөл гаргаснаар шийдүүлэх боломжтой болно.

ДӨРӨВ. СУРГАЛТ

4.1 Боловсрол, гадаад харилцаа, гадаадын иргэн харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын зохих зөвшөөрлийн дагуу Монгол Улсад орж ирсэн суралцагчийг сургалтын нэгдсэн албанаас суралцах сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгчид танилцуулна.

4.2 Суралцагчийн харьяалан суралцах сургууль, тэнхим нь ОТИС-ийн дүрэм, журам, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу чанартай үйлчилгээ үзүүлэх асуудлыг хариуцна.

4.3 ОТИС-ийн суралцагч болсон гадаад иргэн Монгол Улсын харьяат суралцагчийн нэгэн адил дүрэм, журмаар суралцана.

4.4 Суралцагч нэг хичээлийн жилд хоёр удаа буюу оюутны өвлийн болон зуны амралтаар нутагтаа явах эрхтэй. Амралтаараа нутаг явахдаа суралцагч нь чөлөө олгохыг зөвшөөрсөн бүтцийн сургуулийн захирал, Сургалтын нэгдсэн албаны даргын гарын үсэг, суралцаж дууссан улирлын дүнгийн жагсаалтын хамт Гадаад харилцааны албанд өргөдөл гаргаснаас 5 хоногийн дотор Гадаадын иргэн харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандсан гарах орох визний албан бичгийг хийж өгнө.

4.5 Виз бүхий суралцагч нь 90 хүртэлх хоногийн гарах орох визийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хэтрүүлсэн тохиолдолд нэг жилийн ахин визний урилга явуулахгүй бөгөөд оюутантай байгуулсан “Оюутан суралцуулах гэрээ”-г цуцлах үндэслэл болно.

4.6 Суралцагч оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас 2 сарын өмнө ОТИС-ийн гадаад харилцааны албанд мэдэгдэж зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах материалыг бүрдүүлж өгнө. Докторантурт суралцаж танхимийн цагаа бүрэн биелүүлсэн суралцагчдын судалгааны ажлын төлөвлөгөөнд үндэслэн, визийг 3 хүртэлх жилээр сунгах эсэх талаар холбогдох төрийн байгууллагад ОТИС тодорхойлолт гаргаж болно. Судалгааны ажлын төлөвлөгөөг суралцагч, удирдагч нар хамтран төлөвлөж, судалгааны тэргүүлэх профессор хянаж, эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн захирал баталсан байна.

4.7 Суралцагч энэхүү журмын 4.4 дэх хэсэгт заасан үндэслэлээс бусад гэнэтийн болон ар гэрийн гачигдал, судалгаа хийх зорилгоор хичээлийн дундуур нутаг буцах тохиолдолд үндэслэл бүхий өргөдөл гарган мэргэжлийн багш, тэнхим, сургуулийн зөвшөөрлийг авсан байна. Энэ тохиолдолд суралцагчид хичээлийн жилд нэг удаа хураамж авч чөлөө олгоно. Хураамжийн хэмжээ энгийн визний дүнгээс 3 дахин их байна.

4.8 Суралцагч нь тухайн хичээлийн жилд сургуулийн Удирдах зөвлөлөөс тогтоосон гадаад суралцагчийн сургалтын төлбөрийг хичээл эхлэхээс 3 хоногийн өмнө зохих харилцах дансанд тушааж, баримтыг хуулбарын хамт сургуулийн санхүүд өгснөөр сургалтад хамрагдах, номын сангаар үйлчлүүлэх болон бусад үйлчилгээ авах эрх нь нээгдэнэ.

4.9 Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгаснаас гадуур өөрийн хүсэл сонирхлоор хөдөө орон нутагт болон бусад газарт зорчих өөрийн буруутай үйлдлээс холбогдон үүсэх аливаа харилцаанаас бий болох хариуцлагыг суралцагч өөрөө хүлээнэ.

ТАВ. СУРАЛЦАГЧИЙГ ЧӨЛӨӨЛӨХ, ШИЛЖҮҮЛЭХ, ХАСАХ

5.1 Суралцагчийн өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдөх болон бусад сургуульд шилжин суралцах хүсэлтийг хэлэлцэн зөвшөөрсөн бүтцийн сургуулийн саналыг үндэслэн ОТИС-ийн захирлын тушаалаар түүнийг сургуулиас чөлөөлж боловсрол, гадаадын иргэн харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон оршин суух зөвшөөрлийг хасуулж холбогдох зардлыг суралцагчаар гаргуулна.

5.2 Суралцагч жилийн болон хагас жилийн чөлөө хүсэх тохиолдолд сургалтын нэгдсэн алба тухайн оюутны тойрох хуудас, оршин суух зөвшөөрлийг үндэслэн хасуулах тухай захирлын тушаалаар суралцах эрх сэргээх материалыг бүрдүүлж гадаад харилцааны албанд өгнө. Гадаад оюутанд чөлөө олгосон тухай захирлын тушаалыг үндэслэн үргэлжлүүлэн суралцах материалд бүрдүүлэлт хийж оршин суух зөвшөөрөлд хасалт хийлгэнэ.

5.3 Суралцагч өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдөх тохиолдолд хариуцсан сургууль, нэгжийн тодорхойлолт, захирлын тушаалыг үндэслэн судлаагүй үлдсэн хичээлийн багц цагийн төлбөрийг журамд заасан хугацаанд тухайн санхүүгээс буцаан олгоно. Элсэн суралцах хүсэлт гаргасан хэдий ч суралцагч өөрөө ирж суралцаагүй тохиолдолд сургалтын төлбөрийн урьдчилгааг 10 хувийн хасалттай буцааж олгоно.

5.4 Суралцагч Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зүйл, заалт, энэхүү журмын 4-р зүйлийн 4.6, 4.7 дахь хэсгийг зөрчсөн, оюутан

суралцуулах тухай гэрээний сургуулиас хасах үндэслэл бүхий зүйл заалтыг зөрчсөн бол ОТИС-ийн захирлын тушаалаар сургуулиас хасаж боловсрол, гадаадын иргэн харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгуулна.

5.5 Суралцагч энэхүү журмын 5.4 дахь хэсэгт заасан үндэслэлээр сургуулиас хасагдсан тохиолдолд түүний судлаагүй үлдсэн хичээлийн цагийн төлбөрийг буцаан олгохгүй.

ЗУРГАА.ТӨГСӨЛТ

6.1 Тухайн мэргэжлээр сургалтын төлөвлөгөөний дагуу суралцаж, сургалтын агуулгыг бүрэн эзэмшиж зохих үнэлгээ авч төгсөж буй гадаадын төгсөгчийн дипломыг судалсан кредит цагийг илтгэсэн хавсралтын хамт англи, монгол хэл дээр үйлдэж олгоно.

6.2 Суралцагчийн кредит цагийн тооцоо, үнэлгээ, дипломын дүнг нэгтгэн гаргах ажлыг тухайн сургууль, тэнхим хариуцан гаргаж Сургалт, Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал баталгаажуулна.

6.4 Төгсөгчид сургуулийн сургалтын нэгдсэн албанаас олгох тойрох хуудсаар сургуультай тооцоо хийж диплом гардуулах өдрөөс 7 хоногийн өмнө хүлээлгэн өгнө. Хөтөлбөрөө амжилттай дууссан оюутнууд диплом гардуулах өдрөөс өмнө өөрийн хүсэлтээр нутаг буцах тохиолдолд гадаадын иргэний харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хасалт хийлгэж Монгол Улсаас гарна.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1 Суралцагч нь Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зүйл, заалт, энэхүү журмын 4-р зүйлийн 4.6, 4.7 дахь хэсгийг зөрчсөн, оюутан суралцуулах тухай гэрээний сургуулиас хасах үндэслэл бүхий заалтыг зөрчсөн бол ОТИС-ийн захирлын тушаалаар сургуулиас хасаж боловсрол, гадаадын иргэний харьяаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгуулна.

7.2 Энэхүү журмын 7.1-дэх хэсэгт заасан зөрчлөөс бусад зүйл заалтыг зөрчсөн суралцагчдад эхний удаад сануулж, хоёр ба түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд сургуулиас хасах хүртэлх арга хэмжээ авна.